



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/114

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан дөрвөн аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Келсо ХХК "Келсо Центр" зочид буудлын 14/021, Рич Констракшн ХХК "Рич" зочид буудлын 13/164, Нью Саммит ХХК "Саммит" дэн буудлын 15/108, Баянцогт Сонор ХХК "Сонор" дэн буудлын 14/99, Шинэ Ашид ХХК "Амар" дэн буудлын 15/109, Иргэн Л.Мөнхбаатар "Эл Ти" дэн буудлын 15/114 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТСҮХ

УОА0453

E:\NAJG\Alban blanknii helvellt\Tushaal\A\16.12.23 A114.docx

1150501380

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2016 оны 12 сарын 23
өдрийн А/114 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2016.12.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Келсо ХХК	5673062	Бест Вестерн Гобис Келсо	Баянгол дүүрэг, 4-р хороо, П.Жасрайн гудамж 27/01
2	Рич Холдинг ХХК	5621828	Рич	Баянгол дүүрэг, 22-р хороо, Зүүн Нарангийн 18/49

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2016 оны 12 сарын 23
өдрийн А/114 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.12.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Баянцогт Сонор ХХК	5300282	Баянцогт Сонор	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Алтайн 12/352
2	Шинэ Ашид ХХК	5446228	Амар	Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Сэлбийн 1-04 тоот
3	Нью Саммит ХХК	5097738	Саммит	Баянгол дүүрэг, 7-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө 73
4	Иргэн Л.Мөнхбаатар	УХ83022414	Эл Ти	Баянгол дүүрэг, 8-р хороо, 13 байрны 111 тоот

-ooOoo-